



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот

2000 оны нэгдүгээр сарын 29

№4 (141)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

27. Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2000-1-20-ны хууль)	62
28. Гэрээ соёрхон батлах тухай (2000-1-20-ны хууль)	62
29. Гэрээ соёрхон батлах тухай (2000-1-20-ны хууль)	62
30. Хэлэлцээр соёрхон батлах тухай (2000-1-20-ны хууль)	62
31. Гэрээт харуул хамгаалалтын тухай (2000-1-20-ны хууль)	63

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

32. Ерөнхийлөгчийн хоригийн тухай	Дугаар 06	66
33. Тагнуулын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай	Дугаар 07	67
34. Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Ж. Наранцацралтын хамгаалалт, хангамжийн тухай	Дугаар 08	67
35. Засгийн газрын гишүүн байсан зарим хүмүүсийн тэтгэмжийн тухай	Дугаар 09	67
36. Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай	Дугаар 10	67
37. Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 11	68
38. Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 12	68

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

39. Роберт Скалапиног "Найрамдал" медалиар шагнах тухай	Дугаар 07	69
40. Дүрэм батлах тухай	Дугаар 08	69

Дөрөв. ЯАМ, АГЕНТЛАГИЙН АКТ

41. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай (Хууль зүйн сайд, сангийн сайдын хамтарсан тушаал. 1999-12-14 Дугаар 264/203)	71
------------------------------------------------------------------------------------------------------------------------	----

Уншигчдын анхааралд

"Тагнуулын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн 2 дугаар зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр хориг тавьсан тул хуулийн энэ зүйлийг уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 15.2-т "Тагнуулын ерөнхий газрын дэд даргыг Засгийн газар томилж, чөлөөлнө." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)

2 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 14.1-ийг "14.1.Тагнуулын ерөнхий газрын даргыг Засгийн газар Улсын Их Хурлын зохиц байнгын хороотой зөвшилцөж томилж, чөлөөлнө." гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12.1.12 дахь заалтаас "захиалгаар" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 17.2-ыг хүчингүй болсонд тооцсугай.

(Энэ зүйлд Монгол Улсын Ерөнхийлөгч 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр хориг тавьсан тул уг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газрын хооронд 1999 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан Германы Хөгжлийн албаны мэргэжилтнүүдийг ажиллуулах тухай ерөнхий

хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газрын хооронд Японы ахмад сайн дурынхны хөтөлбөрийн талаар хийсэн хэлэлцээний дүнгийн тухай солилцох захидлаар тохирсон гэрээ, түүний

хавсралтыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн хооронд 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан Тайширын усан цахилгаан станцын төслийн

тухай зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь гэрээт харуул хамгаалалт /цаашид "харуул хамгаалалт" гэх/-ын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Харуул хамгаалалтын тухай хууль тогтоомж

2.1.Харуул хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Иргэний хууль², энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1 "харуул хамгаалалт" гэж харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн эд хөрөнгө, объектыг хамгаалах үйл ажиллагааг;

3.1.2."объект" гэж харуул хамгаалалтад авсан барилга байгууламж, бусад зүйлд хамаарах тодорхой орчин, газар нутгийг;

3.1.3."үйлчлүүлэгч" гэж гэрээний үндсэн дээр харуул хамгаалалт хийлгэж байгаа хуулийн этгээд, хувь хүнийг;

3.1.4."харуул хамгаалалтын алба хаагч" гэж харуул хамгаалалтын байгууллагад харуул хамгаалалттай холбоотой тодорхой үүрэг гүйцэтгэж буй этгээдийг;

3.1.5."харуул хамгаалалтын байгууллага" гэж энэ хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийг.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалт болон хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр энгийн жижүүр, манаачийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон харилцаанаас бусад харуул хамгаалалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Харуул хамгаалалтын үйл ажиллагаа

5 дугаар зүйл.Харуул хамгаалалт эрхлэх

5.1.Харуул хамгаалалтын үйл ажиллагааг тусгайлан эрх авсан хуулийн этгээд эрхэлнэ.

5.2.Харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/ олгоно.

5.3.Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд иргэдийн амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд гэм хор учруулахааргүй техник хэрэгсэл ашиглаж болно.

5.4.Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь хууль тогтоомжид заасан галт зэвсэг болон тусгай хэрэгсэл олж авах, бүртгүүлэх, хэрэглэх, хадгалах, биедээ авч явах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, дохиоллын хэрэгсэл ашиглах журмыг чанд баримтална.

6 дугаар зүйл.Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээдэд тавих шаардлага

6.1.Харуул хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь эрх, үүргээ хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, зэвсэг, техник, тусгай хэрэгсэл, хууль тогтоомжийн лавлагаатай байхаас гадна өөрийгөө санхүүжүүлэх чадвартай байна.

7 дугаар зүйл.Харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрөл олгох

¹ Монгол Улсын Үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

² Иргэний хууль –"Ардын эрх" сонинны 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 258; 1995 оны 1 дүгээр сарн 3-ны өдрийн 1; 1995 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2" "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны 1 дүгээрт тус тус нийтлэгдсэн.



7.1.Харуул хамгаалалт эрхлэх байгууллага нь уг үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох материал, алба хаагч тус бүрийн тодорхойлолт, эрүүл мэндийн магадлагааг аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-т ирүүлнэ.

7.2. Аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/ өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч харуул хамгаалалт эрхлэх хүсэлт гаргасан байгууллага энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан, 30 хоногийн дотор зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэж, энэ тухай хариуг бичгээр мэдэгдэнэ.

8 дугаар зүйл. Харуул хамгаалалтын тухай гэрээ

8.1.Харуул хамгаалалт эрхлэх талаар үйлчлүүлэгч болон харуул хамгаалалтын байгууллага гэрээ байгуулна.

8.2.Харуул хамгаалалтын тухай гэрээ байгуулахдаа Иргэний хуульд заасан нийтлэг журмыг баримтлахаас гадна гэрээнд дор дурдсан зүйлийг тусгана:

8.2.1.цагдаагийн байгууллагын зөвшөөрлийн болон татварын байгууллагаас олгосон гэрчилгээний дугаар, он, сар, өдөр;

8.2.2.харуул хамгаалалтын үйл ажиллагааны төрөл, ашиглах техник, тусгай хэрэгсэл;

8.2.3.харуул хамгаалалтын алба хаагчийн тоо, тэдгээрийн ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалалт;

8.2.4.хамгаалалтад авсан объектод нэвтрэн орох, гарах журам;

8.2.5.гэрээний хугацаа;

8.2.6.гүйцэтгэсэн ажлын хөлсний хэмжээ, төлөх журам;

8.2.7.энэ хуулийн 12-17 дугаар зүйлд заасан талуудын эрх, үүрэг;

8.2.8. талуудын хүлээх хариуцлага;

8.2.9.гэрээг цуцлах нөхцөл, түүнээс үүсэх хариуцлага;

8.2.10.гэрээ байгуулсан он, сар, өдөр.

8.3.Энэ хуулийн 8.1, 8.2-т заасан нөхцөлийг хангаагүй гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

8.4.Талуудын хооронд гарсан маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Харуул хамгаалалтын үйл ажиллагааны хязгаарлалт

9.1.Харуул хамгаалалтын байгууллага болон түүний алба хаагч дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

9.1.1.тодорхой хүний хувийн амьдрал, улс төр, шашин шүтлэг, итгэл үнэмшилтэй холбоотой баримт мэдээ цуглуулах, хэвлэн нийлэх;

9.1.2. харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг бусдад шилжүүлэх;

9.1.3.үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийн тухай аливаа мэдээллийг иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөх;

9.1.4.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан зэвсэг, тусгай хэрэгслийг албан үүрэг гүйцэтгэхээс бусад үед биедээ авч явах, хэрэглэх, албан үүрэг гүйцэтгэж байхдаа унтах, байр объектоо орхих, согтууруулах ундааны зүйл хэрэглэх, зэвсэг, хэрэгслээ бусдад шилжүүлэх.

10 дугаар зүйл. Харуул хамгаалалтын алба хаагчийн сургалтын агуулга, төлөвлөгөө

10.1.Харуул хамгаалалтын үйл ажиллагааг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх асуудлыг цагдаагийн төв байгууллага хариуцна.

10.2.Энэ хуулийн 10.1-д заасан сургалтын агуулга, төлөвлөгөө болон сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих журмыг хууль зүйн болон гэгээрлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

10.3.Хуулийн этгээд өөрийн зардлаар энэ хуулийн 10.1-д заасан сургалтад сонирхогч хүнээ суралцуулж болно.

11 дүгээр зүйл. Харуул хамгаалалтын алба хаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг

11.1.Харуул хамгаалалтын алба хаагч ижил загварын дүрэмт хувцас, тухайн байгууллагын онцлогийг тусгасан ялгах тэмдэг хэрэглэх ба тэдгээрийн зардлыг харуул хамгаалалтын байгууллага хариуцна.

11.2.Дүрэмт хувцасны загвар болон ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэх журмыг цагдаагийн төв байгууллага тогтооно.

11.3.Харуул хамгаалалтын алба хаагч



дүрэмт хувцсыг зөвхөн албан үүрэг гүйцэтгэх үед өмсөнө.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Харуул хамгаалалтын байгууллага, алба хаагч болон үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

12 дугаар зүйл. Харуул хамгаалалтын байгууллагын эрх

12.1. Харуул хамгаалалтын байгууллага дараахь эрхтэй:

12.1.1. хамгаалж байгаа эд хөрөнгө, объектын талаар шаардлагатай мэдээлэл авах;

12.1.2. хамгаалж байгаа эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон санал үйлчлүүлэгчид тавих;

12.1.3. хамгаалах эд хөрөнгө, объект нь гэрээнд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй бол хүлээн авахаас татгалзах;

12.1.4. гадаад орны болон өөрийн орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох;

12.1.5. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх.

13 дугаар зүйл. Харуул хамгаалалтын байгууллагын үүрэг

13.1. Харуул хамгаалалтын байгууллага дараахь үүрэгтэй:

13.1.1. харуул хамгаалалтын алба хаагчийг дүрэмт хувцас, ялгах тэмдэг, бусад хэрэгслээр хангах, хууль зүйн болон холбогдох сургалтад хамруулах;

13.1.2. тусгай хэрэгсэл хэрэглэх зааврыг байгууллагынхаа хэмжээнд дагаж мөрдүүлэх;

13.1.3. харуул хамгаалалтын алба хаагчаар 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, зохих боловсрол, ажлын туршлагатай, холбогдох сургалтад хамрагдсан, ял шийтгэлгүй хүнийг ажиллуулах;

13.1.4. үйл ажиллагаатай нь холбогддуулан цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

13.1.5. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад үүрэг.

14 дүгээр зүйл. Харуул хамгаалалтын алба хаагчийн эрх

14.1. Харуул хамгаалалтын алба хаагч дараахь эрх эдэлнэ

14.1.1. хамгаалж байгаа объектод нэвтрэх хүмүүсийн биеийн байцаалтыг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд үйлчлүүлэгч болон холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх;

14.1.2. энэ хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан эрх;

14.1.3. энэ хуулийн 19.1, 20.1-д

заасан тохиолдолд галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэх.

15 дугаар зүйл. Харуул хамгаалалтын алба хаагчийн үүрэг

15.1. Харуул хамгаалалтын алба хаагч дараахь үүрэг хүлээнэ:

15.1.1. хамгаалах эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал, лац ломбыг шалгаж хүлээн авах, хүлээлгэж өгөх, хэрэв эд хөрөнгө, объектын бүрэн бүтэн байдал алдагдсан, лац ломбо хөдөлсөн байвал энэ тухай үйлчлүүлэгчид нэн даруй мэдэгдэх;

15.1.2. хамгаалж байгаа эд хөрөнгө, объектыг байнга шалгаж, хяналт тавьж ажиллах;

15.1.3. хамгаалж байгаа объектод эд хөрөнгө болон бусад зүйлийг оруулж гаргахыг үйлчлүүлэгчийн зөвшөөрлөөр гүйцэтгүүлж энэ тухай тэмдэглэл хөтлөн тухайн хүнээр гарын үсэг зуруулж баталгаажуулах;

15.1.4. албан үүргээ гүйцэтгэхийн өмнө болон гүйцэтгэсний дараа галт зэвсэг, тусгай хэрэгслийг тусгайлан зассан байранд шалгаж хүлээн авах, хүлээлгэн өгөх;

15.1.5. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад үүрэг.

16 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн эрх

16.1. Үйлчлүүлэгч дараахь эрх эдэлнэ:

16.1.1. харуул хамгаалалттай холбогдсон асуудлаар өөрийн ажилтан болон харуул хамгаалалтын алба хаагчид хууль ёсны шаардлага тавих;

16.1.2. харуул хамгаалалтын үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлсэн тохиолдолд гэрээг цуцлах талаар санал гаргах;

16.1.3. харуул хамгаалалтын байдал, гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих;

16.1.4. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад эрх.

17 дугаар зүйл. Үйлчлүүлэгчийн үүрэг

17.1. Үйлчлүүлэгч дараахь үүрэг хүлээнэ:

17.1.1. харуул хамгаалалтын алба хаагчийн гүйцэтгэх үүргийг танилцуулж, заавар, зөвлөмжөөр хангах, шаардлагатай бол зохих баталгаа гаргуулах;

17.1.2. харуул хамгаалалтын алба хаагчид өөрийн байгууллагад гарсан өөрчлөлт, хөдөлгөөнийг цаг тухайд нь мэдэгдэж байх;

17.1.3. харуул хамгаалалтын алба хаагчийг гэрээнд заасан ажиллах нөхцөлөөр хангах;

17.1.4. байгууллагынхаа холбогдох ажилтнуудын хаягийн бүртгэл, хамгаалалтад байгаа объектод байнга нэвтрэх эрх бүхий хүмүүсийн болон эд хөрөнгөтэй харьцах, тэдгээрийг захиран зарцуулах эрх бүхий хүмүүсийн нэрсийг өгөх;

17.1.5. хамгаалалтад авагдсан байр, өрөө, тасалгаа цоожтой байлгаж, ажлын бус цагаар цоожлон лацдаж, түлхүүрийг харуул хамгаалалтын алба хаагчид хүлээлгэн өгөх;

17.1.6. мөнгөн тэмдэгт, үнэт зүйлсийг зориулалтын авдар, хайрцагт хадгалах;

17.1.7. хамгаалж байгаа эд хөрөнгө, объектын хамгаалалтад шаардагдах гал унтраах болон бусад тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, гэрэлтүүлэгчээр хангах;

17.1.8. эд хөрөнгө, объектын хамгаалалтын талаар цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

17.1.9. хууль тогтоомж, гэрээнд заасан бусад үүрэг.

18 дугаар зүйл. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл

18.1. Харуул хамгаалалтын алба хаагч албан үүрэг гүйцэтгэхдээ албаны нохой болон галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, хамгаалах тусгай хэрэгсэл, зэвсэггүй тулалдах мэх хэрэглэж болно.

19 дүгээр зүйл. Галт зэвсэг хэрэглэх

19.1. Хамгаалж байгаа эд хөрөнгө, объект болон өөрт нь шууд заналхийлж зэвсэг хэрэглэсэн, эсхүл бүлэглэн халдсан тохиолдолд харуул хамгаалалтын алба хаагч аргагүй хамгаалалтын хүрээнд галт зэвсэг хэрэглэж болно.

19.2. Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст энэ хуулийн 19.1-д зааснаас бусад тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийг хориглоно.

19.3. Харуул хамгаалалтын алба хаагч боллоцтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна.

19.4. Галт зэвсэг хэрэглэснээс хүний эрүүл мэндэд хохирол учирсан бол харуул хамгаалалтын алба хаагч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

19.5. Харуул хамгаалалтын алба хаагч галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэггүйгээр тулалдах мэх хэрэглэх, албаны нохой ашиглах зааврыг Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

20 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх

20.1. Харуул хамгаалалтын алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэнийг хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох боломжгүй бол харуул хамгаалалтын алба хаагч мэх, дараахь нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно:

20.1.1. гав;

20.1.2. хүлэг;

20.1.3. резинэн ба цахилгаан

бороохой;

20.1.4. нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

20.1.5. резинэн ба хуванцар сумтай буу

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

21 дүгээр зүйл. Харуул хамгаалалтын үйл ажиллагаанд тавих хяналт

21.1. Харуул хамгаалалтын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд цагдаагийн байгууллага хяналт тавина.

21.2. Цагдаагийн байгууллага энэ хуулийн 21.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохих баримт бичиг шаардан гаргуулах, тодорхойлолт авах эрхтэй.

22 дугаар зүйл. Харуул хамгаалалтын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

22.1. Харуул хамгаалалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх түүнд дараахь шийтгэл ногдуулна:

22.1.1. зөвшөөрөлгүйгээр харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлсэн хуулийн этгээдийг 200000-250000 хүртэл төгрөгөөр торгож, хууль бусаар олсон орлого, техник хэрэгслийг хурааж;

22.1.2. энэ хуулийн 5.4, 9.1.1, 9.1.2, 9.1.3-ыг зөрчсөн гэм буруутай харуул хамгаалалтын алба хаагчийг 10000-50000, албан тушаалтныг 35000-60000 хүртэл төгрөгөөр торгох.

23 дугаар зүйл. Харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгох

23.1. Харуул хамгаалалтын байгууллага энэ хуулийн 9.1.2-ыг зөрчсөн болон цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон нь тогтоогдвол аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/ харуул хамгаалалт эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгож, энэ тухай холбогдох байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Ерөнхийлөгчийн хоригийн тухай



Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12.1.12 дахь заалт; 14.1; 15.2; 17.2 дахь хэсэгт тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Тагнуулын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Тагнуулын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай

1. Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах газрын нэрийг Монгол Улсын Тагнуулын ерөнхий газар болгон өөрчилсүгэй.

Хуульд заасан дүрэм, журмыг батлан мөрдүүлэх арга хэмжээг 2000 оны 1 улиралд багтаан хэрэгжүүлэхийг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

2. Тагнуулын байгууллагын тухай хуульд Засгийн газрын шийдвэрүүдийг нийцүүлэх, мөн

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо /Н.Алтанхуяг/-нд даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 9 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Ж.Наранцацралтын хамгаалалт, хангамжийн тухай бүрэн эрхийн хугацаанд хамгаалах ажлыг Төрийн тусгай хамгаалалтын газар /Г.Жаргалсайхан/-т хариуцуулсугай.

1. Монгол Улсын Ерөнхий сайдын алба хашиж байсан Жанлавын Наранцацралтыг нэгэн

2. Энэ тогтоолын 1-д заасан хугацаанд Ж.Наранцацралтад шуурхай ажлын суудлын автомашинаар үйлчлэхийг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын гишүүн байсан зарим хүмүүсийн тэтгэмжийн тухай

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Ж.Наранцацралт, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан Л.Цог нарт тодорхой ажил, албан тушаал эрхлээгүй нөхцөлд Улсын Их Хурлын 1999 оны 66 дугаар тогтоолоор тогтоосон цалин, бусад нэмэгдэлтэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг 6 сарын хугацаагаар олгохоор тогтоосугай.

2. Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байсан Ж.Наранцацралт, Засгийн газрын гишүүнээр ажиллаж байсан Л.Цог нарыг энэ тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан хугацааны дотор тодорхой ажил, албан тушаал эрхлүүлэх талаар арга хэмжээ авах, хэрэв ажил, албан тушаалд томилогдвол ажил, албан тушаалын цалин хөлс нь энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан хэмжээнээс бага байвал зөрүүг тооцож олгохыг Засгийн газар /Р.Амаржаргал/-т даалгасугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн өндөр албан тушаалтны цалингийн хэмжээг нэмэгдүүлэн тогтоох тухай тушаалын цалингийн хэмжээг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 25 хувиар нэмэгдүүлэн тогтоосугай.

Төрийн өндөр албан тушаалтны албан

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын прокурорын байгууллагын прокурорын албан тушаалын сарын цалингийн хэмжээг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хавсралт ёсоор шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 68 дугаар тогтоолын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 11 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалин /төгрөгөөр/
1.	Ерөнхий прокурор	93544
2.	Ерөнхий прокурорын орлогч	83490
3.	Ерөнхий прокурорын газрын туслах прокурор	80565
4.	Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор	73879
5.	Нийслэлийн прокурор	80163
6.	Нийслэлийн прокурорын орлогч	73508
7.	Нийслэлийн прокурорын газрын туслах прокурор	68750
8.	Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор	67500
9.	Дүүргийн ахлах прокурор	70180
10.	Дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор	66853
11.	Аймаг, тээврийн прокурор	76835
12.	Аймаг, тээврийн прокурорын орлогч	71088
13.	Аймаг, тээврийн прокурорын газрын туслах прокурор	68750
14.	Аймаг, тээврийн прокурорын газрын хяналтын прокурор	67500
15.	Сум, сум дундын ахлах прокурор	70180
16.	Сум, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор	66853

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын шүүхийн шүүгчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хавсралт ёсоор шинэчлэн тогтоосугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын 1999 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 69 дүгээр тогтоолын 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ



Монгол Улсын Их Хурлын 2000 оны
12 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛЫН САРЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Албан тушаал	Албан тушаалын сарын цалин /төгрөгөөр/
1.	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	96044
2.	Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч	87725
3.	Улсын дээд шүүхийн шүүгч	83490
4.	Нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	80163
5.	Нийслэлийн шүүхийн шүүгч	73508
6.	Дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	70180
7.	Дүүргийн шүүхийн шүүгч	66853
8.	Аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч	76835
9.	Аймгийн шүүхийн шүүгч	71088
10.	Сум, сум дундын шүүхийн Ерөнхий шүүгч	70180
11.	Сум, сум дундын шүүхийн шүүгч	66853

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 1 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Роберт Скалапиног "Найрамдал"
медалиар шагнах тухай

Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд биечлэн оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Америкийн Нэгдсэн Улсын Ази судлалын нэрт эрдэмтэн Роберт Скалапиног

"Найрамдал" медалиар шагнаусугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 1 дүгээр
сарын 20-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

Зарлиг болгох нь:

1. "Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын төрийн шагналын тухай дүрэм"-ийг мөрдөхгүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н. БАГАБАНДИ

2. Дүрмийг шинэчилсэнтэй холбогдуулан Монгол улсын Ерөнхийлөгчийн 1997 оны 19

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 08
дугаар зарлигаар шинэчлэн батлав

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ШАГНАЛЫН ТУХАЙ ДҮРЭМ

1. Монгол Улсын иргэдийн авьяас билэг, оюуны бүтээлийг төрөөс шалгаруулан үнэлж Монгол Улсын төрийн шагнал олгож байна.

2. Төрийн шагналыг шинжлэх ухаанд нээлт хийсэн, шинэ онцгой технологи буй болгосон, оюуны соёлын гоц үнэт бүтээл туурвисан хүмүүст хүртээнэ.

3. Шинжлэх ухаан, технологийн бүтээлүүдийг их, дээд сургууль, мэргэжлийн байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ШУА-ийн холбогдох салбарын Бага чуулганаас; хөгжим, уран барилгын бүтээлүүдийг уран бүтээлийн эвлэл холбоодын хамтын удирдлагын хурлаар хэлэлцэж, Соёл урлагийн их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаас; зохиолч,

яруу найрагчдын бүтээлийг утга зохиолын холбогдох үндэсний төвийн хурлаар хэлэлцэж зохиолчдын эвлэлүүдийн удирдах зөвлөлүүдийн хамтарсан хурлаас тус тус нэр дэвшүүлнэ.

Нэр дэвшсэн бүтээл нь шат шатны хуралдаанд оролцогсдын дөрөвний гурваас доошгүй хувийн саналаар дэмжигдсэн байвал зохино. Саналыг нууцаар хураана.

Саналын хуудас, тооллогын комиссын тогтоолыг шат шатны хуралдааны албан тэмдэглэлд хавсаргана.

Монгол Улсын Ерөнхийлөгч төрийн шагналд нэр дэвшүүлж болно.

1. Төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлийг энэ дүрмийн хавсралтанд заасан бүрдүүлвэл зохих баримт бичгүүдийн хамт тухайн оны 4 дүгээр сарын 20-ны дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт ирүүлнэ. Тамгын газар баримт бичгүүдийг нарийвчлан бүртгэн авч, ажлын хэсгүүдэд хүлээлгэн өгнө.

Тайлбар:

а. Монгол Улсын Ерөнхийлөгч тодорхой бүтээлийг төрийн шагналд нэр дэвшүүлбэл эл дүрмийн дагууд судлан шинжилж шийдвэрлэнэ.

б. Төрийн шагналд хамтын бүтээл нэр дэвшиж байгаа бол нэр дэвшигчдийн бүрэлдхүүн уг бүтээлийг туурвихад зохиогчийн эрхэд хүрэх хэмжээний хувь нэмэр оруулсан 3 хүртэл хүнтэй байвал зохино.

5. Төрийн шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээнэ.

6. Төрийн шагнал хүртээх бүтээлийг судлан шалгаруулах үүднээс Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд:

- Төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлээс сонгон шалгаруулах ажлын хэсэг,

- Сонгон тодруулсан бүтээлд хянан магадлагаа хийх шинжээчийн ажлын хэсгийг жил бүр томилон ажиллуулна.

- 7. Ажлын хэсгүүдийг байгуулахдаа:

а/ ажлын хэсгүүдэд өмнө жилийн бүрэлдэхүүнээс гуравны нэг хүртэл хувийг нь оруулж болно;

б/ төрийн шагнал хүртээх бүтээлийг сонгон тодруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан хүнийг шинжээчийн ажлын хэсэгт оруулж болно;

в/ төрийн шагналд бүтээл нь нэр дэвшсэн хүнийг ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнд оруулахгүй.

8. Ажлын хэсэг тус бүр 15 хүртэл хүнтэй байна.

9. Бүтээлийг сонгон тодруулах ажлын хэсгийг Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын захирамжаар тухайн оны 1 дүгээр улиралд багтаан байгуулна.

а/ ажлын хэсэг нь шинжлэх ухаан, технологи, урлаг, утга зохиолын тэргүүлэх

эрдэмтэд, мэргэжилтэн, төрийн шагналтан, нэр хүнд бүхий хүмүүсээс бүрдэнэ.

б/ сонгон тодруулах ажлын хэсэг төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлүүдийг Ерөнхийлөгчийн Тамгын газраас хүлээн авч шалгаруулалтанд оруулна.

в/ ажлын хэсэг төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлд судалгаа хийсэн дүн, сонгон тодруулсан бүтээлийн тухай танилцуулгыг тухайн оны 6 дугаар сарын 15-ны дотор Ерөнхийлөгчийн тамгын газарт ирүүлнэ.

10. Төрийн шагнал хүртээхээр сонгон тодруулсан бүтээлд хянан магадлагаа хийх шинжээчийн ажлын хэсгийг Ерөнхийлөгчийн захирамжаар томилно. Шинжээчийн ажлын хэсэгт тухайн салбарын тэргүүлэх эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оруулна.

а/ шинжээчийн ажлын хэсэг нь сонгон тодруулах ажлын хэсгээс ирүүлсэн бүтээлүүдэд хянан магадлагаа хийж хоёр дахь шатны шалгаруулалтанд оруулан төрийн шагнал олгож болно гэж үзсэн бүтээлийн тухай үндэслэл, дүгнэлт, саналаас шагналыг гардуулах хугацаанаас 14-өөс доошгүй хоногийн өмнө Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

б/ Монгол Улсын Ерөнхийлөгч шинжээчийн хэсгийн үндэслэл, саналыг судалж, зөвшөөрвөл Монгол Улсын төрийн шагнал хүртээх тухай зарлиг гаргана.

11. Хэсгүүд Ерөнхийлөгчийн захирамжаар баталсан "Монгол Улсын төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлээс сонгон тодруулах болон сонгон тодруулсан бүтээлд хянан магадлагаа хийх шинжээчийн ажлын хэсгүүдийн ажиллах журам"-ыг мөрдөнө.

12. Хэсгүүд төрийн шагнал хүртээх бүтээлтэй танилцан шалгаруулахдаа мэргэжлийн байгууллага, хүмүүс, олон нийтийн санаа бодол, бүтээлийн талаар гарсан санал, шүүмжийг сайтар харгалзвал зохино.

13. Төрийн шагналд нэр дэвшиж олон нийтэд зарлагдсан бүтээлийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд саналаа Ерөнхийлөгчийн тамгын газарт ирүүлнэ. Саналыг 9 дүгээр сарын 1-ний дотор бүртгэж авна.

14. Төрийн шагнал хүртээхээр шинжээчийн ажлын хэсгээс санал болгосон бүтээлүүдийн талаар Засгийн газарт Ерөнхийлөгчийн тамгын газраас танилцуулна.

15. Төрийн шагналыг жил бүрийн намрын дунд сарын шинийн 17-ны билэг дэмбэрэлт өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч ёс төгөлдөр гардуулна.



16. Төрийн шагнал хүртэгчдэд энгэрийн тусгай тэмдэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын үсэг бүхий төрийн шагналтны үнэмлэхийг дагалдах мөнгөний хамт олгоно. Шагналыг дагалдах мөнгөний хэмжээ 10 цэн алтны үнэтэй тэнцэнэ.

17. Монгол Улсын Төрийн шагналыг нэг жилд 5 хүртэл бүтээлд хүртээж болно.

18. Төрийн шагнал хүртээх бүтээлийг сонгон тодруулах болон хянан магадлагаа хийхээр томилогдсон хүмүүст ажлын хөлс олгоно.

19. Төрийн шагнал хүртсэн бүтээлүүдийн тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг Ерөнхийлөгчийн тамгын газрын архивт хадгална.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 08 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-ийн хавсралт

ТӨРИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШСЭН БҮТЭЭЛИЙГ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР ИРҮҮЛЭХДЭЭ БҮРДҮҮЛБЭЛ ЗОХИХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1. Материал хүргүүлэх тухай нэр дэвшигчийн ажилладаг байгууллага, газрын албан тоот,
2. Нэр дэвшигчийн анкет /маягт №1/
3. Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт,
4. Нэр дэвшсэн бүтээл, бүтээлийн тодорхойлолт, товч танилцуулга /оюуны үнэ цэнэ, шинэлэг санаа, сэдэв ойролцоо бусад бүтээлээс юугаараа давуу, ач холбогдол, практик үр өгөөж, эдийн засгийн тооцоо, хамрах хүрээ, чанар, хүртэц, нөлөө гэх мэт/,
5. Нэр дэвшсэн бүтээл гадаад дотоодод үнэлэгдсэн байдал,
6. Нэр дэвшүүлсэн газрын тогтоол,
7. Бүтээлийг шат шатанд хэлэлцсэн албан тэмдэглэл,
8. Тухайн салбар хариуцсан сайдын зөвлөлийн хуралдаанаас гаргасан санал дүгнэлт,
9. Оюуны өмчийн газрын тодорхойлолт, үнэлэлт,
10. Нэр дэвшигчийн бусад бүтээлийн жагсаалт,
11. Хэрэглэгч, сонирхогч байгууллага, хүмүүсийн санал, шүүмж,
12. Холбогдох бусад баримт бичиг /шинэ бүтээлийн гэрчилгээ, эрдмийн зэрэг, цолны үнэмлэхийн хуулбар гэх мэт/.

ХУУЛЬ ЗҮЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

1999 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 264/203

Улаанбаатар хот

Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

ТУШААХ нь:

1. Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1997 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 275/359 дүгээр тушаалаар батлагдсан "Хөрөнгийн үнэлгээ хийх зөвшөөрөл олгох журам"-ын зарим заалтанд дараахь нэмэлт өөрчлөлт оруулсугай.

а/ журмын 5 дахь заалтын "болон хураангуй" гэснийг хасах,

б/ журмын 2 дахь хэсгийн 8 дахь заалтыг "Хууль зүйн сайд, Сангийн сайдын тушаалаар томилогдсон орон тооны бус комисс / цаашид комисс гэх/ нь үнэлгээгчдийн сонгон шалгаруулалт болон мэргэжлийн аттестатчиллыг шаардлагатай

бол жилд нэг удаа тус тус эрхлэн явуулна. Сонгон шалгаруулалт болон мэргэжлийн аттестатчиллыг "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ" "Тоног төхөөрөмжийн үнэлгээ", "Бизнес үнэлгээ"-ний сургалтад хамрагдагсдаас тус тусын чиглэлээр нь шалгалт авч сонгон шалгаруулалтад тэнцсэн хүмүүст комиссын саналыг үндэслэн Хууль зүйн ба Сангийн сайдын гарын үсэг бүхий гэрчилгээг дээрх төрлөөр олгоно. Нэг хүн үнэлгээний энэхүү 3 төрлийн шалгалтад орж болно. Гэрчилгээ авсан этгээд үнэлгээний компани байгуулах эрхтэй" гэж өөрчлөх,

в/ журмын 19 дэх заалтыг хасах,

г/ журмын 20 дахь заалтыг "Үл



хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар үл хөдлөх хөрөнгө болон тоног төхөөрөмжийн үнэлгээнд, Үнэт цаасны хороо бизнесийн үнэлгээнд тус тус хяналт тавьж энэ талаар гарсан маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ” гэж өөрчлөх,

д/ Журмын 21 дэх заалтын “газар” гэсний дараа “болон Үнэт цаасны хороо” гэж нэмэх,

е/ 3 дугаар хэсэгт “Хэт зөрөөтэй үнэлсний улмаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учирсан бол хохирлыг үнэлгээ хийсэн, гэрчилгээ олгосон, баталгаанд тооцож гэрээний гүйцэтгэл хангуулсан этгээдийн гэм буруутай байдлыг харгалзан хувь тэнцүүлэн нөхөн төлүүлэнэ” гэсэн 22, “мэргэжлийн аттестатчилалд тэнцээгүй бол тухайн үнэлгээчин сонгон шалгаруулалтад 1 жилийн дараа дахин орж эрхээ сэргээлгэж болно” гэсэн 23 дахь заалтыг тус тус нэмэх,

2. Үнэлгээчдийг сонгон шалгаруулах

орон тооны бус комиссын бүрэлдэхүүнийг хавсралтын ёсоор баталсугай.

2. Комиссын ажиллах журмыг 12 дугаар сарын 25-ны өдөрт багтаан боловсруулж Хууль зүйн сайдын тушаалаар батлуулах, 2000 оны 1 дүгээр сард үнэлгээчдэд аттестатчилал явуулахыг комиссын дарга /Г. Пүрэвцэрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн сайд Сангийн сайдын 1997 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 275/359 дүгээр тушаалын 2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тушаалаар тогтоосон нэмэлт өөрчлөлтийг 1999 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагалж мөрдсүгэй.

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

ДАШ. ГАНБОЛД

САНГИЙН САЙД

Я. ОЧИРСҮХ

Хууль зүйн сайд, Сангийн сайдын халтарсан 1999 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 264/203 дугаар тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭЧДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ОРОН ТООНЫ БУС КОМИСС

Комиссын дарга: Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газрын дарга

Комиссын нарийн бичгийн дарга: Үл хөдлөх эд хөрөнгийн хяналтын албаны дарга

Гишүүд: Үнэт цаасны хорооны Бүртгэл санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Хууль зүйн яамны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газрыг хариуцсан мэргэжилтэн

Сангийн яамны Бүтцийн өөрчлөлтийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Төрийн өмчийн хорооны жижиг аж ахуйн нэгж, үл хөдлөх хөрөнгийн хувьчлалын албаны дарга

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 329612
Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх үйлдвэрт хэвлэв.

☎ 329487